



**“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
ТОГТООЛ**

2024 оны 08 дугаар сарын 26 өдөр

Дугаар 01

Тавантолгой

Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тодотгол хийж, төрийн аудитын байгууллагад мэдээлсэн тухай танилцуулга

Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.1 дэх заалт, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.8 дахь заалт, Тооллогын комиссын 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Тавантолгой” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тодотгол хийж, төрийн аудитын байгууллагад мэдээлсэн тухай хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсныг тэмдэглэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Г.ЦОГ-ӨРНӨХ



**“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
ТОГТООЛ**

2024 оны 08 дугаар сарын 26 өдөр

Дугаар 02

Тавантолгой

Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тодотгол хийж, төрийн аудитын байгууллагад мэдээлсэн тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 62.1.15 дахь заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дахь заалт, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.14.9 дэхь заалт, Тооллогын комиссын 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн 2023 үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тодотгол хийж, төрийн аудитын байгууллагад мэдээлсэн тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.
2. Хуралд танилцуулсан дүгнэлтийг цаашид бодлого шийдвэртээ тусгаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ЦОГ-ӨРНӨХ



**“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
ТОГТООЛ**

2024 оны 08 дугаар сарын 26 өдөр

Дугаар 03

Тавантолгой

Компанийн 2023 оны ногдол ашиг хуваарилах тухай
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолыг хэлэлцэх тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь заалт, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.14.13 дахь заалт, Тооллогын комиссын 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн 2023 оны ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолын хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд танилцуулсныг тэмдэглэсүгэй.
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэрийн дагуу нэмэлт ногдол ашиг хуваарилах, хувьцаа эзэмшигчдэд бүрэн олгох ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ЦОГ-ӨРНӨХ



**“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
ТОГТООЛ**

2024 оны 08 дугаар сарын 26 өдөр

Дугаар 04

Тавантолгой

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон
хараат бус гишүүдийг томилох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.4 дэх заалт, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9, 6.14.7 дах заалт, Тооллогын комиссын 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн, хараат бус гишүүдийг санал хураах кумулятив аргыг ашиглан дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгосугай. Үүнд:
 1. Сүрэнхүүгийн Мятавдорж /ердийн гишүүн/
 2. Бямбаагийн Мэндбаяр /ердийн гишүүн/
 3. Шаравын Отгонбаяр /ердийн гишүүн/
 4. Эрдэнэчулууны Бөхбат /ердийн гишүүн/
 5. Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ /ердийн гишүүн/
 6. Цэнд-Аюушийн Цэнгэлбаяр /ердийн гишүүн/
 7. Галсандоржийн Цог-Өрнөх /хараат бус гишүүн/
 8. Лхачингийн Батчулуун /хараат бус гишүүн/
 9. Даваадоржийн Дэлгэрцогт /хараат бус гишүүн/
2. Шинээр сонгогдсон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг хууль тогтоомжийн дагуу идэвхи санаачлагатай ажиллахыг үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ЦОГ-ӨРНӨХ